



АМРАЛТ



АВСАН НЬ



ӨДӨР БҮР ХИЙХ ЁСТОЙ МАШ ОЛОН АЖЛУУД БЯЦХАН

ТАРВАГАНД БАЙДАГ. ХАРИН БЯЦХАН ТАРВАГА ӨДӨР БҮР ЭДГЭЭР

Зүйл

ЗҮЙЛҮҮДИЙГ ХИЙХЭЭС ЗАЛХАЖ БАЙЛАА. ШҮДЭЭ УГААХАА

БИТГИЙ МАРТААРАЙ! ГЭЖ АAB НЬ ТҮҮНД ХЭЛЭВ. БЯЦХАН

ТАРВАГА ШҮДЭЭ УГААХЫГ ХҮСЭХГҮЙ БАЙГАА ТУЛ САНАА АЛДЛАА.



  

ХООЛНЫХОО НОГООНУУДЫГ ИДСЭН БИЗ?

    

ГЭЖ ААВ НЬ АСУУЛАА. ХАРИН БЯЦХАН ТАРВАГА

   

ЯМАР Ч НОГОО ИДЭХИЙГ ХҮСЭХГҮЙ БАЙВ.





“ОДОО ХЭДЭН ЦАГ БОЛЖ БАЙГАА БИЛЭЭ?"



ГЭЖ ААВ НЬ ТҮҮНЭЭС АСУУВ.



БЯЦХАН ТАРВАГА ХАРИУД НЬ УУРЛААД ЯРВАЙЖ



ОРХИЛОО. ААВ НЬ ГАЙХАН ТҮҮНЭЭС ДАХИАД



АСУУВ. ХАРИН БЯЦХАН ТАРВАГА "УНТАХ ЦАГ" ГЭЖ ХАРИУЛЛАА.





МАРГААШ ӨГЛӨӨ НЬ БЯЦХАН ТАРВАГАНД НЭГ САЙХАН САНАА



ТӨРЖЭЭ. ТЭР ААВДАА “БИ ӨДӨР БҮР ХИЙХ ЁСТОЙ АЖЛУУДАА



ХИЙХГҮЙ АМРАЛТ АВМААР БАЙНА" ГЭЖ ХЭЛЭВ. ААВ НЬ ХАРИУД



НЬ "ХММ..., ЧИ ХҮССЭН БОЛ ТЭГДЭЭ” ГЭХ НЬ ТЭР. БЯЦХАН



ТАРВАГА АМРАЛТАА АВАХЫГ ТЭСЭН ЯДАН ХҮЛЭЭЖ БАЙЛАА.




БЯЦХАН


ТАРВАГА


ТЭР


ӨДӨРТӨӨ

ЯМАР Ч


НОГОО


ИДСЭНГҮЙ.



 

ТЭР ШҮДЭЭ Ч, БҮР

 

НҮҮРЭЭ Ч УГААСАНГҮЙ.



    

УНТАХ ЦАГ БОЛСОН Ч БЯЦХАН ТАРВАГА

  

УНТСАНГҮЙ. "ЭНЭ БОЛ ХАМГИЙН

    

САЙХАН АМРАЛТ" ГЭЖ БЯЦХАН ТАРВАГА ХЭЛЭВ.



 

  

ХАРИН МАРГААШ ӨГЛӨӨ НЬ БЯЦХАН ТАРВАГАНД

    

ИХ Л ХАЧИН БАЙЛАА. ТҮҮНИЙ ШҮД НЬ ӨВДӨЖ

   

ГЭДЭС НЬ ЭВГҮЙРХЭВ. БАС ӨМНӨХ ОРОЙ НЬ

   

ЭРТ УНТААГҮЙ УЧРААС МАШ ИХ ЯДАРСАН БАЙЛАА.




БЯЦХАН


ТАРВАГА


ӨДӨР БҮР


ХИЙДЭГ


АЖЛУУД НЬ


ЮУНД


ХЭРЭГТЭЙГ

САЯ Л


ОЙЛГОВ.



   

ТЭР ШҮДЭЭ МАШ САЙН УГААГААД

  

ЗОГСОХГҮЙ ХООЛНЫХОО БҮХ НОГООГОО

 

ИДЭХ НЬ ТЭР. ТҮҮГЭЭР Ч БАРАХГҮЙ ТЭР

  

ОРОЙДОО АРАЙ ЭРТ УНТАХААР ХЭВТЛЭЭ.